Баянзүрх дүүргийн 0-23 сартай хүүхдийн хоол тэжээл, бие бялдрын хөгжлийн судалгаа

Б.Уянга[1], Д.Ганзориг[2], М.Эркебулан[3], Б.Баасанжаргал[4]

[1,3,4]АШУҮИС
[2]Эрүүл Мэндийн Яам
Цахим хаяг: mmelody0508@gmail.com, Утас:83138113

Түлхүүр үг:
Өсөлтийн хоцрогдол
Эхийн боловсрол
Амжиргааны түвшин

Товч утга: Монгол улс бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдалд анхаарч, олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ч хүүхдүүдийн хоол тэжээлийн өнөөгийн байдал санаа зовоосон асуудлын нэг байсаар байна. Нийгмийн эрүүл мэндийн асуудалд хүүхдийн витамин, эрдэс баялгийн дутагдал, биеийн өсөлт хөгжлийн дутмаг асуудал хэвээр байсаар байна. Бид судалгаандаа Баянзүрх дүүргийн 2 хорооны 0-23 сартай хүүхдүүдийг хамруулан тэдний хоол тэжээлийн байдлыг эхийн боловсрол, амьжиргааны түвшинтэй харьцуулан үнэлэхэд насны хувьд 21-24 сартай хүүхдүүд илүү их өсөлтийн хоцрогдолтой, тусгай дунд боловсролтой ээжүүдийн хүүхдүүд өсөлтийн хоцрогдолд өртөх эрсдэл дээд боловсролтой ээжүүдийн хүүхдүүдээс 2.02 дахин их байсан. 2018 оны нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнтэй харьцуулахад намхан, өсөлт хоцрогдолтой хүүхдийн хувь буурсан сайн үр дүн байгаа ч хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүд өсөлтийн хоцрогдолд өртөх эрсдэл их байсаар байна.

Үндэслэл: Дэлхий даяар жилд дунджаар 10 сая хүүхэд урьдчилан сэргийлж болох өвчнөөр хорвоог орхидог ба 5-аас доош насны хүүхдүүдийн нас баралтын бараг тэн хагас нь хоол тэжээлийн дутагдалтай холбоотой байна.[1] Дэлхий дахинд 1990 оноос хойш нялхас, бага насны хүүхдийн хоол тэжээлд онцгой анхаарч ирсэн. ДЭМБ 2006 онд зохион байгуулсан “Олон Улсын Харилцан Зөвшилцлийн Уулзалт”-аас “Нялхас, бага насны (0-5 хүртэлх) хүүхдийн хоол тэжээлийн байдлыг газар нутаг, үндэс угсаа, хооллолт, цаг уур нийгэм эдийн засгийн байдал зэргээс үл хамаарах олон улсад хэрэглэж болох хүүхдийн өсөлт хөгжлийн “Z” оноог тооцож үнэлэх шинэчилсэн шалгуур үзүүлэлт”–ийг баталсан. Энэ нь бага насны хүүхдийн эхийн сүүгээр хооллолт, нэмэгдэл хооллолтын байдлыг үнэлэх боломжийг олгосон юм. Бага насны хүүхдийг ДЭМБ–ын “Нялхас, бага насны хүүхдийн хооллолт”–ын зөвлөмжийн дагуу хооллоход өсөлт хоцролтыг хүүхдийн амьдралын эхний 2 жилд бууруулж чадсан байдаг.[4] Манай улс ДЭМБ боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандартыг хүлээн зөвшөөрч 2010 оноос эхлэн хоол тэжээлтэй холбоотой бүх судалгаа, тандалтын бүх үйл ажиллагаанд ашиглах болсон.5 Монгол улсад туранхай хүүхдийн эзлэх хувь 1999 оноос хойш харьцангуй бага, харин өсөлт хоцролтын тархалт 20 хувиас дээш түвшинд байсан.[6] Бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдалд анхаарч, олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ч хүүхдүүдийн хоол тэжээлийн өнөөгийн байдал санаа зовоосон асуудлын нэг байсаар байна. Иймд сүүлийн жилүүдэд нийт өрх хүн амын амьжиргааны түвшин, боловсрол сайжирсантай холбоотойгоор бага насны тэр дундаа 0-23 сартай хүүхдийн хоол тэжээлийн өнөөгийн байдлыг судлан дүгнэх шаардлагатай юм.

Зорилго: БЗД-ийн 0-23 сартай хүүхдүүдийн хоол тэжээлийн байдлыг үнэлэх

Зорилт:

1. 0-23 сартай хүүхдүүдийн хоол тэжээлийн байдлыг амьжиргааны түвшинтэй харьцуулан дүгнэх
2. 0-23 сартай хүүхдүүдийн хоол тэжээлийн байдлыг эхийн боловсролтой харьцуулан дүгнэх

Арга аргачлал: Улаанбаатар хотын хүн ам ихтэй дүүрэг болох БЗД-н хороодоос сонгон авч, 0-23 сартай хүүхдүүдийг 2006 оноос эхлэн НҮБ Хүүхдийн сан, ДЭМБ-ийн зөвлөмж болгон боловсруулсан стандартын дагуу үнэлнэ. Энэхүү стандартын хүснэгт нь хүүхдийн хоол тэжээлийн байдлыг гурван шалгуур үзүүлэлтээр үнэлэн стандарт голч утгаас хэлбэлзэх стандарт хазайлтаар /z утгууд/ тодорхойлон статистик боловсруулалтыг SPSS, Excel программыг ашиглан хийнэ. Амьжиргааны түвшин, эхийн боловсролыг Засгийн газрын 404 дүгээр тогтоол болон "Боловсролын тухай" хуульд заасны дагуу ангилна.

Үр дүн: Судалгаанд нийт 2 хорооны 0-23 сартай 1501 хүүхэд (785 эрэгтэй, 716 эмэгтэй) болон ээжүүд хамрагдсан. Нийт хүүхдүүдийн 448 (29.8%) 1-5 сартай, 351 (23.4%) 6-10 сартай, 318 (21.2%) 11-15 сартай, 243 (16.2%) 16-20 сартай, 141 (9.4%) 21-23 сартай.

Ээжүүдийн боловсролын хувьд 183 (12.2%) бага, 303 (20.2%) дунд, 175 (11.7%) мэргэжлийн, 840 (56%) дээд боловсролтой. Амьжиргааны түвшин 115 (7.7%) доод, 396 (26.4%) харьцангуй бага хэрэглээтэй, 629 (41.9%) дундаж, 277 (18:5%) дунджаас дээгүүр, 84 (5.6%) илүү өндөр хэрэглээтэй өрх хамрагдсан.

1-5 сартай хүүхдүүдийн 24 (5.9%), 6-10 сартай хүүхдүүдийн 13 (3.9%), 11-15 сартай хүүхдүүдийн 23 (8%) 16-20 сартай хүүхдүүдийн 24 (10.2%), 21-24 сартай хүүхдүүдийн 19 (14%) өсөлтийн хоцрогдолтой байгаа ба насны хувьд 21-24 сартай хүүхдүүд илүү их өсөлтийн хоцрогдолтой байна. (P=0.0001). Эрэгтэй хүүхдүүдийн 64 (8.7%), эмэгтэй хүүхдүүдийн 39 (5.8%) өсөлтийн хоцрогдолтой байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Өсөлтийн хоцрогдлын тохиолдлыг насны бүлэг, хүйсээр харуулав

Үзүүлэлт	Нийт тоо	хэвийн		өсөлтийн хоцрогдолтой		P утга
		тоо (хувь)	95% и.и.	тоо (хувь)	95% и.и.	
Насны бүлэг						**0.0001**
1 - 5 сартай	409	385 (94.1)	91.5 - 96.1	24 (5.9)	3.9 - 8.5	
6 - 10 сартай	336	323 (96.1)	93.7 - 97.8	13 (3.9)	2.2 - 6.3	
11 - 15 сартай	287	264 (92)	88.4 - 94.7	23 (8)	5.3 - 11.6	
16 - 20 сартай	236	212 (89.8)	85.5 - 93.2	24 (10.2)	6.8 - 14.5	
21 - 24 сартай	136	117 (86)	79.5 - 91.1	19 (14)	8.9 - 20.5	
Хүйс						**0.036**
Эрэгтэй	733	669 (91.3)	89.1 - 93.2	64 (8.7)	6.8 - 10.9	
Эмэгтэй	671	632 (94.2)	92.2 - 95.8	39 (5.8)	4.2 - 7.8	
Нийт	**1404**	**1301 (92.7)**	**91.2 - 93.9**	**103 (7.3)**	**6.1 - 8.8**	

Өсөлтийн хоцрогдолд өртөх эрсдэл дээд боловсролтой ээжүүдтэй харьцуулахад бага боловсролтой ээжүүдийн хүүхдүүдэд OR 1.23 (P= 0.528), мэргэжлийн боловсролтой ээжүүдийн хүүхдүүдэд OR 2.02 (P=0.012), дунд боловсролтой ээжүүдийн хүүхдүүдэд OR 1.12 (P=0.681) байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Өсөлтийн хоцрогдолд өртөх эрсдэл эхийн боловсрол, амьжиргааны түвшингөөр (Засгийн газрын 404 дүгээр тогтоол, "Боловсролын тухай" хуульд заасан ангиллын дагуу)

Хувьсагч	OR	95% C.I.for OR		P утга
		Lower	Upper	
Ээжийн боловсрол				
Бага	1.23	0.65	2.31	0.528
Дунд	1.12	0.65	1.92	0.681
Мэргэжлийн	2.02	1.17	3.49	**0.012**
Дээд	**1**			
Амьжаргааны түвшин				
Доод	1.94	0.66	5.70	0.226
Бага хэрэглээтэй	1.06	0.39	2.84	0.916
Дундаж	1.05	0.40	2.75	0.921
Дунджаас дээгүүр	1.11	0.40	3.07	0.847
Өндөр хэрэглээтэй	**1**			

Хэлцэмж: Нийгмийн олон үзүүлэлт түүвэр судалгаанд 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн байдлын үнэлгээнд жил бүр өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн эзлэх хувь 2000 онд 25%, 2005 онд 21%, 2010 онд 15%, 2013 онд 11%, 2018 онд 9% болж тус тус буурсан ч хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүд илүү их өсөлтийн хоцрогдолтой гэсэн үр дүн гарсан байдаг.[8] Бидний судалгаанд хамрагдсан 1501 хүүхдүүдийн дунд өсөлтийн хоцрогдолтой хүүхдүүд 7.3% байгаа нь хүүхдийн хоол тэжээлийн дутагдал жил ирэх тусам буурч байгааг илтгэх сайн үр дүн билээ. Харин хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүд өсөлтийн хоцрогдолд илүү өртөх эрсдэл хэвээр байна.

Дүгнэлт: Хүйсийн хувьд эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдээс илүү өсөлтийн хоцрогдолд өртөж байгаа бол мэргэжлийн боловсролтой ээжүүдийн хүүхдүүд өсөлтийн хоцрогдолд өртөх эрсдэл дээд боловсролтой ээжүүдийн хүүхдүүдээс 2.02 дахин их байна. Амьжиргааны түвшингөөр судлан үзэхэд амьжиргааны доод түвшний өрхийн хүүхэд өндөр хэрэглээтэй өрхийн хүүхдээс 1.94 дахин өсөлтийн хоцрогдолд өртөх хандлагатай байгаа ч нийт судалгаанд оролцогчдыг хувьд ач холбогдол бүхий үр дүн гараагүй.

Ном зүй:

1. *P. Pinstrup-Andersen, "The food system and its interaction with human health and nutrition," in Leveraging Agriculture for Improving Nutrition and Health, pp. 1–4, International Food Policy Research Institute, Washington, DC, USA, 2011.)*
2. *WHO Child Growth Standards WHO Child Growth Standards 1 year 2 years 3 years 4 years 5 years Length/height-for-age, weight-for-age, weight-for-length, weight-for-height and body mass index-for-age Methods and development /19-26x/*
3. *Interpreting growth indicators world health organization 2008 /14-22x/*
4. *Монгол улс Мянганы хөгжил зорилтуудын хэрэгжилт үндэсний 5 дахь илтгэл /46-50x/*
5. *Хүүхэд хөгжил 2005 судалгаа /12-14x/*
6. *Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018 /189-202x/*

Nutrition and physical development research for the children who are 0-23 months old in Bayanzurkh District

B.Uyanga[1], D.Ganzorig[2], M.Erkebulan[3], B.Baasanjargal[4]

[1,3,4]MNUMS
[2]Ministry of Health
Email: mmelody0508@gmail.com, Tel: 83138113

Even though children's nutritional status is taken attention by Mongolians and they are fulfilling many projects, today's children's nutritional status is one of the concerned problems. Children's lack of vitamins and minerals and their growth deficiency are still social health problems. We have encompassed 0-23 month's old children who live in 2 committee of Bayanzurkh district on our survey. After we had compared their nutritional status to their mothers' education and living standards, we realized that 21-24 months old children have more growth deficiency and the children of mothers with secondary education have 2.02 times higher risk of growth retardation than the children of mothers with bachelor's degree or higher. Compared to the results of the 2018 Social Indicators Survey, it is a good result that the percentage of children with growth retardation has diminished. Nevertheless, there is still high risk of growth deficiency for boys by sex.

Key word: Bayanzurkh district, physical development, nutrition